

07 дугаар сарын үйл ажиллагааны мэдээ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Ардын хувьсгалын 99 жил, үндэсний их баяр наадмын үндэсний сур харвааны эмэгтэй төрөлд Баруун-Урт сумын харъяат аймгийн мэргэн, спортын мастер Л.Одсайхан түрүүлж "Монгол Улсын мэргэн" цол хүртлээ. Түүний хувьд Сүхбаатар аймгаас тодорч буй анхны эмэгтэй Улсын мэргэн болж буй юм. Тус аймгаас сур харвааны төрөлд оролцож өндөр амжилт гаргаж байсан түүхийг сөхвөл Ардын хувьсгалын анхны наадмын сур харваанд их жанжин Д.Сүхбаатар оролцон түрүүлж байсан удаатай.

Аймгийн Онцгой комисс хуралдаж Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий баар, караоке, ангиллын аж ахуй нэгж, шашин соёл урлаг, үзвэр үйлчилгээний байгууллага, хүүхдийн тоглоомын газрын үйл ажиллагааг эхлүүлэх зөвшөөрөл хүссэн санал, хүсэлтийг шийдвэрлэж мэргэжлийн байгууллагуудад энэ чиглэлийн үзлэг шалгалтыг хийх, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах талаар үүрэгжүүллээ. Мөн уг хурлаар Бичигт боомтоор нэвтрэх уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтийг эхлүүлэхээр шийдвэрлэсний зэрэгцээ Гамшигт үзэгдлийн улмаас Эрдэнэцагаан, Түвшинширээ, Баруун-Урт, Мөнххаан зэрэг сумдад учирсан хор хохирлын хэмжээ, түүнийг барагдуулах тухай хүсэлтийг хэлэлцэж, Улсын Онцгой комисст уламжлахаар боллоо.

а. ИТХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээлэл: Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид хуралдаж:

1. Сонгуулийн хороо байгуулах тухай
2. Төрийн дээд одонд тодорхойлогдсон иргэдийн материалыг хэлэлцэх
3. Үндсэн хөрөнгө бүртгэж эзэмшүүлэх тухай
4. Үндсэн хөрөнгө орон нутгийн өмчөөс хасах тухай
5. Үндсэн хөрөнгө акталж данснаас хасах зөвшөөрөл олгох тухай
6. Зөвшөөрөл хүсэх тухай зэрэг асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэлээ.

Ардын хувьсгалын 99 жил үндэсний их баяр наадмын үндэсний сур харвааны эмэгтэй төрөлд түрүүлж "Монгол Улсын мэргэн" цол хүртсэн Баруун-Урт сумын харъяат аймгийн мэргэн, спортын мастер Л.Одсайханд аймгийн ИТХ-ын дарга Б.Мөнхбат хүндэтгэл үзүүлж, Аймгийн ИТХ-ын "Хүндэт тэмдэг"-ээр шагнаж урамшууллаа.

б. Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл: Аймаг болон сумд Тулгар төрийн 2229, Их Монгол Улс байуулагдсаны 814, Ардын хувьсгалын 99, Сүхбаатар аймаг байгуулагдсаны 78 жилийн үндэсний их баяр наадмын үйл ажиллагааг 07 сарын 11, 12-ны өдрүүдэд эрүүл ахуй, халдвар хамгааллын дэг журмыг сахиулж, ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүллээ.

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай аймгийн Засаг даргын А/406 дугаар захирамжаар нийтийн эзэмшлийн чийрэгжүүлэлтийн болон биеийн тамир, спортын талбайнуудыг нээж, үйл ажиллагааг хэвийн голдиролд нь орууллаа. Үүнтэй холбоотойгоор дээрх талбайнуудын аюулгүй байдлыг хангуулж, сагсны цагираг, хөл бөмбөгийн тор, шийд зэргийг хураагаад байсныг гаргаж байршуулахыг холбогдох газруудад үүрэг болгов.

Мөн архи, согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөлтэй хүнсний дэлгүүрийн согтууруулах ундаа худалдах цагийн хуваарийг 08:00-17:00 цаг хүртэл хэвээр үлдээж, харин хүнсний худалдаанаас бусад тусгай зөвшөөрөлтэй нийтийн хоол үйлдвэрлэлийн аж ахуй нэгжийн ажиллах цагийн хуваарийг 2020 оны 07 дугаар сарын 15-ны өдрийг дуустал 08:00- 22:00 цаг хүртэл ажиллуулахаар боллоо.

Хоёр. Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд:

2020 оны 7 дугаар сард улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгээр болон тусгай зориулалтын шилжүүлгийн орлогоор нийт 27,825,9 сая төгрөг авч, орон нутгийн төсөвт

4,310,5 сая төгрөгийн орлого орж нийт 32,139,4 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж ажиллаа.

Эхний 7 сарын байдлаар Улсын төсөвт 1648,2 сая төгрөг төвлөрүүлэхээс 1282,8 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 77,83 хувиар, Орон нутгийн төсөвт 5560,5 сая төгрөг төвлөрүүлэхээс 5121,2 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 92,09 хувиар тус тус биелүүлсэн байна.

Аймгийн төсвөөс сумдад 3,393,5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, орон нутгийн төсвийн 13 байгууллага болон тусгай зориулалтын шилжүүлгийн 56 байгууллагад нийт 29,327,2 төгрөгийн санхүүжилт олгож байгууллагууд үйл ажиллагаагаа хэвийн явуулсан болно.

ОНХНС-ийн орлогын шилжүүлэг/ эхний хагас жилийн байдлаар өссөн дүнгээр/ төлөвлөгөө 5810803,7 мян.төгрөг, гүйцэтгэлээр 3291,3 сая төгрөг. Үүнээс 2,036,1 сая төгрөг нь Төсвийн тухай хуулийн 60.2.6, 60.2.7 дэх эх үүсвэр болох ашиглалт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл болон мега төслийн АМНАТ төлбөр болно. Үүнийг холбогдох журмын дагуу хуваарилан сумдад 1,283,5 сая төгрөг хуваарилсан.

Санхүүгийн хяналт, аудитын алба: Баруун-Урт сумын иргэнээс ирсэн өргөдөл гомдлын дагуу Сүхбаатар-Уул уурхай ОНӨААТҮГазарт санхүүгийн хяналт шалгалт хийж хуулийн байгууллагад шилжүүлээ. Мөн албаны даргын баталсан удирдамжийн хүрээнд аймгийн Сүхбаатар Тохижилт-Үйлчилгээ ОНӨААТҮГазрын 2019-2020 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлж ажиллалаа.

Статистикийн хэлтэс: Хүн ам, орон сууцны тооллогын хүснэгтүүдийн тоо мэдээллийг нягтлан, шалгаж, анхаарал татсан хүснэгтүүдийг ахин тодруулж ажиллалаа. Мөн хүн ам, орон сууцны тооллогын хураангуй тайланг бичиж төвд дамжуулан, тооллогын товчоогоор хянуулан аймгийн тооллогын комисст танилцуулаад байна.

Хөдөө аж ахуйн түүвэр судалгааны /Малын ашиг шим болон газар тариалангийн судалгаа/ эхний 2 улирлын мэдээллийг сонгогдсон 8 сумын 8 багийн 160 өрхөөр бөглүүлэн татан авч, хянаж шалгах ажил хийж, програмд оруулан Үндэсний статистикийн хороонд хугацаанд нь хүргүүлээд байна.

Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны А/198 дүгээр тушаал болон аймгийн Засаг даргын 2020 оны А/30 дугаар захирамжаар заагдсан 2-р улирлын албан статистикийн мэдээ, тайланг авах графикайн дагуу 7 дугаар сарын 21-ний өдрийг хүртэл 215 аж ахуйн нэгжийн мэдээ, тайланг авч нэгтгэн, онлайн програмд шивж хугацаанд нь 100 хувь хамралттай хийж гүйцэтгэсэн.

Гурав. Нийгмийн бодлогын хүрээнд:

Боловсрол, соёл урлагийн чиглэлээр: Аймгийн хэмжээнд бүрэн дунд сургууль төгсөгчдийн элсэлтийн ерөнхий шалгалтыг батлагдсан журмын дагуу дагуу амжилттай зохион байгууллаа.

Байгалийн гамшигт өртсөн Түвшинширээ суманд ажиллаж усанд автсан цэцэрлэгийн барилгын байдалтай танилцан мэдээллийг холбогдох байгууллагуудад хүргүүллээ. Шинээр бариглаж байгаа Түвшинширээ, Уулбаян сумын соёлын төвийн барилга, Уулбаян сумын дотуур байр, Түвшинширээ сумын сургуулийн их засварын ажилтай танилцлаа.

Боловсрол, соёл, урлагийн байгууллагуудын 2021 оны төсвийн төслийн боловсруулан, нэгтгэж байна.

Үндэсний бичиг үсгийн баярыг тохиолдуулан Монгол үндэсний бичиг үсгээ дээдэлж, үндэсний өв соёлоо сэргээн хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, хойч үедээ өвлүүлэн үлдээх, монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх, хүүхэд залуусын авьяасыг нээн хөгжүүлэх зорилгоор зохион байгуулагдсан “Монгол бичиг үсгийн гайхамшиг” уран бичлэгийн уралдааныг бүх насныхны дунд зохион байгуулахад нийт 10 гаруй бүтээл ирснээс эхний байруудыг шагнаж, урамшуулав.

"Шинэ номын тойм"-оо цахим хэлбэрээр цувралаар хүргэн ажиллаж, цахим үйлчилгээг үр дүнтэй ашиглаж байгаа талаар МОНЦАМЭ агентлагийн хуудсаар дамжуулан сурталчлав.

Өглөөний ургах нартай уралдан өөрсдийгөө хөгжүүлж яваа залуучуудад зориулан "Өглөөний гайхамшиг" номын яриа хэлэлцүүлгийн зохион байгуулан ажиллаж байна.

Аймгийн Угсаатны зүйн музейн сан хөмрөгт хадгалагдаж шилдэг 50 үзмэрийн зургийг авхуулж ил захидал хийлгэхээр эх бэлтгэгдэж байна. Үүнд: Мөнгөн аяга, Шашин, Цом, Шилдэг-10, Хөөрөг, зэргээр ил захидал гаргахаар ажиллаж байна.

Зүүн Монгол Дорнын гоёл” дуу, хөгжим, бүжгийн чуулбарыг Дарьганга суманд дүрсжүүлэх дарьгангын брэнд болгох төсөлт ажлыг эхлүүлэн ажиллаж байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр: Үндэсний их баяр наадмын хурдан морьны унаач болон уяачдад өгөх зөвлөгөө зөвлөмжийг боловсруулж, унаач хүүхдийн аюулгүй байдлыг хангаж хүүхэд хамгааллын ажлыг зохион байгуулсан.

Гэр бүлийн зөрчил гаргасан баривчлагаанд байгаа 2 эрэгтэйд сэтгэлзүйн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэв. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хүрээнд 2021 оны үйл ажиллагааны төсвийг боловсруулж байна. Сүүлийн 3 жилд залуучуудын чиглэлээр хийсэн үйл ажиллагааны үр дүн, үр ашигийн талаарх тайлан мэдээг нэгтгэн хуулийнхугацаанд хүргүүллээ.

Гэр бүл дэх хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах, эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхэд, гэр бүлийн зөрчилийг илрүүлэх, иргэдийг сонсох, Корона вируст Ковид-19 халдварт цар тахлын аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Гэрээр айлчлах” 1 сарын аянг аймгийн хэмжээнд зохион байгуулж, нийт өрхийн 10 хувьд хүрч ажилласан байна. Гэр бүлийн зөрчил үйлдэж Аймгийн цагдаагийн газарт баривчлагдсан иргэдэд “Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалт”-ын хөтөлбөрийн хүрээнд зохион байгууллаа

ШУ-ны үндэслэлтэй угийн бичиг хөтлөх арга зүй” сэдэвт 10 цуврал теле хичээлийг бэлтгэн орон нутгийн телевиз, олон нийтийн хэрэгслээр дамжуулан иргэдэд хүргэж байна.

7-р сарын байдлаар ХТУ-108 төвд 6 дуудлага мэдээлэл ирж, мэдээллийн дагуу харъяалагдах газарт шаардлагатай үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Мөн харъяаллын дагуу хамтарсан багт хувийн хэргийг шилжүүлж аргазүйгээр ханган ажиллаж байна.

“Үндэсний их баяр наадам”-аар хурдан морины уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг ханган ажиллаж, уралдаанч хүүхдийн бүтгэлийг зохион байгуулж ажилласан. Сүхбаатар аймгийн улсын баяр наадмаар нийт 350 морь, 161 хүүхэд бүртгүүлсэн байна.

Эрүүл мэндийн чиглэлээр: ДЭМБ, ЭМЯ, ХӨСҮТ, ЭХЭМҮТ төвөөс хамтран “Коронавируст халдвар (COVID-19)-ын сэргийлэлт, хяналт ба эмнэлзүйн менежмент” сэдвээр орон нутагт 21 сургагч багш бэлтгэв

Үндэсний их баяр наадмын үеэр ЭМС-ын 2020 оны А/36 дугаар тушаал, Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны 362 дугаар албан даалгаварын дагуу эрүүл мэндийн байгууллагуудын хариуцлагатай жижүүрийг томилгоожуулан баяр наадмын өдрүүдэд 136 эмч эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүллээ.

2020 оны 7 сарын 11- 15-ны хугацаанд өдөр бүрийн 08 цаг, 15 цагийн байдлаар эрүүл мэндийн байгууллагуудаас эмнэлгийн тусламж үйлчилгээний мэдээг авч нэгтгэн ЭМХТ-д өглөөний 8 цагт burtgel.mohs.mn хаягаар, Шуурхай штаб, МХГ, Тагнуулын хэлтэст 08:00 цаг, 14:00 цагт утсаар болон имэйлээр хариуцлагатай жижүүрт мэдээлсэн. Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан COVID -19 халдвараас сэргийлэх , гар халдваргүйжүүлэх, амны хаалт зүүх, зай барих зэрэг санамж зөвлөмжийг наадмын талбай, морь барианы газруудад байршуулав. Хурдан морины унаач 2337 хүүхдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулан халууныг хэмжин, гарыг халдваргүйжүүлж, осол гэмтлээс сэргийлэх зөвлөмж өгч ажилласан.

“Коронавируст халдвар (COVID-19)-ын сэргийлэлт, хяналт ба эмнэлзүйн менежмент” сэдвээр орон нутгийн сургагч багш нар 12 сумын эрүүл мэндийн төвийн эмч эмнэлгийн мэргэжилтнүүд, сумын засаг даргын тамгын газрын мэргэжилтэнүүд болон АНЭ, өрх , хувийн хэвшлийн эмнэлгүүдийн эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургалтанд хамруулж байна.

Уул уурхайн тээвэрлэлт эхлэхтэй холбоотой Бичигт боомтоор тээвэрлэлт хийх компаниудын бэлтгэл бэлэн байдалтай газар дээр нь очиж танилцав

МУ-ын ЗГ-ын 213 дугаар тогтоолын дагуу Гадаадын мэргэжилтнүүд МУ-ын хилээр орж ирэхтэй холбоотойгоор Цайрт минераль ХХК, Эл эм цахиурт компаниудын бэлтгэл бэлэн байдлыг хангуулах чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

Эрдэнэцагаан, Асгат сумдад явуулын амбулатори 8 хоногийн хугацаатай ажиллав. 6 сумын эрүүл мэндийн төвийн 2020 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийв.

Коронавируст халдварын хяналт сэргийлэлттэй холбоотой гарсан тушаал шийдвэрийн хэрэгжилт, цар тахлын эрсдлийн “маш өндөр” үеийн төлөвлөгөөний биелэлтийг тус тус ЭМЯ –д тайлагнав. Тарваган тахлын эсрэг вакцинд ОБГ,ЦГ,МХГ, Мал эмнэлгийн газар, Хил хамгаалах байгууллага, эрүүл мэндийн байгууллагын нийт 535/95% албан хаагчдыг хамрууллаа

Хөдөлмөр эрхлэлтийн талаар: "Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр"-ийн START-UP сургалт болон аж ахуй эрхлэлтийн сургалтыг “Бэст Мэтод” сургалтын байгууллагатай хамтран 6 дугаар сарын 26-28ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. START-UP сургалтанд 13 сумын 16 баг, аж ахуй эрхлэлтийн сургалтанд 13 сумын 40 иргэн хамрагдаж сертификат гардан авлаа. START-UP сургалтад оролцсон 16 баг бизнесийн шилдэг санаагаа танилцуулсанаас 8 баг бизнес хурдасгуурт оролцох батламж гардан авлаа. Үүнээс шалгарсан 5 багт 10 сая төгрөгний эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгоно. Мөнххаан, Түвшинширээ, Уулбаян, Дарьганга сумдад хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хэрэгжиж буй хөтөлбөрийн хэрэгжилт, үйл ажиллагаатай танилцаж зөвлөгөө мэдээлэл өгч ажиллав.

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт байгаатай холбогдуулан 2017-2019 онуудад хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 25 иргэнтэй утсаар холбогдож 7 иргэний эргэн төлөлтийн хугацааг хойшлуулж гэрээг шинэчлэн байгуулав.

Нийгмийн халамжийн талаар: 2020 оны 07 дугаар сарын байдлаар нийгмийн халамжийн тэтгэвэрт 1903000,0 мян.төг, тэтгэмжинд 663000.0 мян.төг, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 411384.0 мян.төг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлтөнд 100000,0 мян.төг, ахмад настанд үзүүлэх хөнгөлөлтөнд 232000,0 мян.төг, хүнс тэжээлийн хөтөлбөрт 763744, мян.төг, алдарт эхийн одон 680200,0 мян.төг, алдар цолтой ахмадын хөнгөлөлтөнд 16600,0 мян.төг, насны хишиг 203740,0 мян.төг, цалинтай эхийн тэтгэмж 160166,0 мян.төг, өрх толгойлсон эцэг/эхийн тэтгэмж 98400,0 мян.төг, ихэр хүүхдийн тэтгэмж 36000,0 мян.төг, орон нутгаас 49200,0 мян.төгрөгийн санхүүжилтийг авч арилжааны банкаар дамжуулан иргэдэд олгоод байна.

Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаанд хамрагдах 29 өрхөд судалгаа хийж мэдээллийн санд оруулав. Ахмадын амралт сувиллын 10 дугаар ээлжинд 47 ахмад настан амарч, бариа засал, бумба, төөнүүр, цахилгаан массажны аппарат, шарлага, хануур, хаш чулуун ор, зөгийн балны татлага, гүүний саам зэрэг эмчилгээ, үйлчилгээг үзүүлж байна. Улаанбаатар хотын “МОН-АНИР” ХХК –тай гэрээ байгуулан ажилласнаар ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй 51 иргэнд дижитал сонсголын аппарат тохирууллаа. ХХҮЕГ-тай гэрээтэй Алсын-Оч нүдний шилний компани ирж ахмадын амралтанд амарч байгаа 64 ахмад настанд нүдний шил хийлгэж хөнгөлөлт үзүүлсэн байна.

2020 оны 06 дугаар сарын 29 – ны өдрөөс 5 хоногийн хугацаатай аймгийн Улаан загалмайн хороотой хамтран өдрийн үйлчилгээний II дахь ээлжийг зорилтот болон хөгжлийн бэрхшээлтэй 28 иргэнийг өдрийн 2 ээлжээр явуулж ажиллалаа.

Пипл ин нийд олон улсын төрийн бус байгууллагын хүсэлтийн дагуу Баруун-Урт суманд 2020 онд хөгжүүлэхээр сонгосон амьжиргааны түвшин доогуур 73 өрхөд тусламж дэмлэг үзүүлж хамтран ажиллах саналыг хүргүүлээд байна.

Баруун - Урт сумын өрх толгойлсон эх/эцэг, ганц бие ахмад настан, хөхүүл болон олон хүүхэдтэй эх, хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй зэрэг шалгаантай 50 өрхөд Монголын улаан загалмайн хороотой хамтран хүнс тэжээл болон ахуйн хэрэглээний эд материалын тусламж үзүүлж ажиллалаа.

Дөрөв. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хүрээнд:

Дэд бүтэц, газрын харилцааны чиглэлээр: Баяндэлгэр суманд Худалдаа үйлчилгээ, Үйлдвэрлэлийн зориулалтаар 2 байршилд газар эзэмших эрхийн нээлттэй дуудлага худалдаа танхимын хэлбэрээр зохион байгуулагдсан. Уг газар эзэмших эрхийн дуудлага худалдаанаас орон нутгийн төсөвт нийт 8,0 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн. Үйлдвэрлэлийн зориулалтаар зарласан дуудлага худалдаа оролцогчгүйн улмаас хүчингүй болсон. Мөн Баруун-Урт, Түвшинширээ суманд 2 байршилд үйлдвэрлэлийн зориулалтаар

газар эзэмших эрхийн нээлттэй дуудлага худалдааг танхимын хэлбэрээр зохион байгуулахаар зарлаж оролцогчдыг бүртгэж байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар 7 иргэнд 0,48 га газрыг өмчлүүлэхээр, дуудлага худалдаанд ялагч болсон 1 аж ахуйн нэгж байгууллага, 2 иргэнд 0,21 га газрын шинээр эзэмшүүлэхээр, 4 иргэнд 0,064 га газрын газар эзэмших эрх шилжүүлэхээр, 2 иргэний өмчлөлийн газрын хэмжээ өөрчлөх шийдвэрүүдийг гаргуулж, кадастрын зураг хэвлэн баталгаажуулж, гэрчилгээжүүлсэн.

Аймгийн ГХБХБГ-ын ажлын хэсэг Уулбаян, Түвшинширээ, Мөнххаан, Түмэнцогт сумдад шинээр баригдаж байгаа болон их засвар хийгдэж байгаа барилга байгууламжийн ажилтай танилцан, хяналт хийж заавар зөвлөмж өгч ажиллалаа.

Барилгын хөгжлийн төвийн дэд захирал Э.Энхболдоор ахлуулсан ажлын хэсэг Түвшинширээ, Уулбаян, Баруун-Урт сумдуудад ажиллаж барилга угсралтын үед гарсан зөрчил, дутагдалуудыг арилган ажлыг цааш үргэлжлүүлэх талаар албан шаардлага өгөн ажиллаж байна. Мөн цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлын явцтай танилцаж заавар зөвлөмж өгч ажилласан.

Барилгын материалын, сорилт шинжилгээний лабораторит 3 шинжилгээ хийгдсэн байна. Бетон шоо-2, Тоосго-1, шинжилгээ хийн үр дүнг боловсруулан цаг тухай бүрт нь хариуг олгон ажиллаа.

Хөдөө аж ахуйн салбарт: Зах зээл ба бэлчээр менежментийн удирдлагын төслийн хөрөнгөөр хийгдэх Баяндэлгэр, Эрдэнэцагаан сумдын малчдын сургалт мэдээллийн төвийг тохижуулах, Хүнс хөдөө аж ахуйн газрын сургалтын танхимын тоног төхөөрөмж худалдан авах тендерт “Сибирь трейвэл”ХХК шалгарч гүйцэтгэхээр болсон.

Аймгийн жишсэн дундаж хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээ, нийтийн хоолны салбарын хүнсний нөөцийн судалгааг сумдаар нэгтгэн гаргаж 7 хоногийн 3 дахь өдөр сумдын хүнсний дэлгүүр, худалдааны төв, мал, мах бэлтгэн нийлүүлэгч нараас хүнсний бүтээгдэхүүний хангамж, нөөц, түүхий эдийн нөөц талаарх мэдээг ХХААХҮЯ-ны ХҮБХЗГ хүргүүлж ажиллалаа.

Бизнес эрхлэгчдийн ур чадварыг дээшлүүлэх, бүтээгдэхүүний үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор эрчимжсэн аж ахуй эрхлэгч 10 төлөөллийг Хэнтий аймгийн Батширээт, Норовлин, Баян-Овоо сумдын эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийн сүүний үйлдвэр, фермерийн үйл ажиллагаатай танилцуулж туршлага судлах аялалд хамрууллаа.

Мал эмнэлгийн газар: Мал эмнэлгийн газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг Асгат, Эрдэнэцагаан, Дарьганга, Наран, Онгон, Баяндэлгэр сумдад 4 хоног ажиллаж сумдын мал эмнэлгийн тасгийн мэргэжилтүүд болон мал эмнэлэг үйлчилгээний нэгжийн эмч нартай уулзаж 2020 онд хийгдсэн хаврын шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын явцад хяналт хийж мөн шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга /угаалга, туулга, боловсруулалт/ хэмжээний явц, гүйцэтгэлийн байдалтай танилцаж мал эмнэлгийн цахим системд оруулах арга хэмжээг зохион байгуулан, үүрэг чиглэл өгч ажилласан.

Лабораторийн ажлын талаар: Мал амьтнаас хүнд дамжин халдварладаг бруцеллөз өвчнийг эрт үед нь оношлох урьдчилан сэргийлэх арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх зорилгоор Улсын мал эмнэлэг ариун цэврийн лабораторитой 2020 байгуулсан гэрээ гэрээний дагуу Мал эмнэлгийн лабораторийн эрхлэгч М.Бүтэнжаргалаар ахлуулсан ажлын хэсэг Түвшинширээ, Уулбаян, Мөнххаан, Түмэнцогт очиж 4250 хээлтүүлэгч малаас цусны дээжийг цуглуулж шинжилсэн.

Баяндэлгэр суманд колибактериоз, Халзан суманд цусан халдварт өвчин оношлогдож тухайн өвчинтэй тэмцэх зааврын дагуу заавар зөвлөмжийг өгч сумын Засаг даргаар хязгаарлалтын дэглэм тогтоож, урьдчилан сэргийлэх вакцинжуулалт, халдваргүйтгэлийн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

2020 онд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг бүрэн татан авч сумын мал эмнэлгийн тасагт хуваарилан олгож гүйцэтгэлийн материалыг хүлээн авч хянан үйлчилгээний хөлс болох 34,4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс олгоод байна.

Эрчим хүчний чиглэлээр: Уулбаян сумын 35кВ-ын ХБ 15кВ-ын хуурай салгуур, ТП113, 07, 37, 14 дэд станцуудад хуурай салгуур суурилуулж, Онгон сумын дэд станцын элегаз таслуур шинэчилсэн. Мөн 35 / 15кВ-ын Халзан дэд станцын 15кВ-ын Хуурай салгуур шинэчилсэн 15кВ-ын реле хамгаалалтын блок шинэлик, Өндөрхаан-Баруун-Уртын

110кВ-ын ЦДАШ-д засвар, АТП№38, 39, 96, 40, 41 дэд станцуудад трансформаторын ажлын тавцан хийх зэрэг ажлуудыг хийсэн байна.

Жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр: Монгол Улсын Засгийн газрын санаачилгаар хэрэгжүүлж буй “Зүүн бүсийн эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг хангахад хувийн хэвшлийн оролцоог дэмжих нь” ТТ-9751 мон төслийн хүрээнд төслийн багийн зүгээс Сүхбаатар аймгийн бизнес эрхлэгчдэд “Бизнес хөгжил болон бүтээгдэхүүн үйлчилгээний маркетинг” сэдэвт танхимын сургалтыг Сүхбаатар аймагт зохион байгуулж орон нутгийн бизнес эрхлэгчдийн 15 төлөөлөл оролцуулж, сертификат олгосон.

Олборлох салбарыг үр дүнтэй удирдаж, орон нутгийн үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааг ханган улс, орон нутгийн эдийн засгийг сэргээж тогтвортой өсөлт бий болгох зорилгоор Канад улсын гадаад хэргийн яамнаас санхүүжүүлэн Сүхбаатар аймагт хэрэгжүүлж байгаа “Мерит” төслөөс санаачлан ШУТИС-ын Бизнесийн ахисан түвшний сургуультай хамтран “Бизнесийн удирдлага, төлөвлөлт модуль-2” төсөл боловсруулах, түүнийг амжилттай удирдах арга зам” сэдвийн хүрээнд орон нутгийн бизнес эрхлэгчдэд зориулсан сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтад 6 сумын 30 гаруй биенес эрхлэгчид хамрагдан сургалтын сертификатыг гардан авсан байна.

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах тухай хүсэлт гаргасан аж ахуй нэгжүүдэд аймгийн Засаг даргын 2020 оны 07 дугаар сарын 03 –ны 3-ны өдрийн А/723 дугаар захирамжаар 1 аж ахуй нэгжид шинээр олгох, 2 аж ахуй нэгжийн тусгай зөвшөөрлийг сунгах, мөн 2020 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/474 -р Захирамжаар 2 аж ахуй нэгжид шинээр, 3 аж ахуй нэгжийн тусгай зөвшөөрлийг сунган гэрчилгээ олгоод байна.

Тав. Бусад салбарт хийгдсэн ажил:

Онцгой байдлын газар: Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан Эрүүл мэндийн байгууллагуудад хийх шалгалтын удирдамжийн дагуу гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын чиглэлээр 2020 оны 06 дугаар сарын 15-ний өдрөөс 07 дугаар сарын 06-ны өдрийн хооронд хяналт шалгалтыг холбогдох хууль тогтоомж, стандарт, техникийн норматив, дүрэм, журмын дагуу зохион явууллаа.

Төлөвлөгөөт шалгалтыг нийт 10 Эрүүл мэндийн байгууллагад явуулснаас 106 зөрчил илрүүлж, үзлэг шалгалтын явцад 54 зөрчлийг арилгуулж, 52 зөрчлийг арилгуулахаар 8 заавал биелүүлэх албан шаардлага 1 танилцуулга хүргүүлэн биелэлтийг хангуулан ажиллаж байна. Аж ахуйн нэгж байгууллага хүсэлт өгсөний дагуу нийт 20 барилга байгууламжид хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, гал гарч болзошгүй 125 зөрчил илрүүлэн газар дээр нь 52 зөрчлийг арилгуулж бусад зөрчлийг арилгуулахаар заавал биелүүлэх албан шаардлага 10, мэдэгдэл 1, дүгнэлт 1-ийг тус тус үйлдэн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Гал түймрийн хэрэг зөрчилтэй холбоотой гомдол мэдээллийг тогтмол хүлээн авч 3 удаагийн гал түймрийн гарч 1 хэрэг зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж гал түймэр гарсан тухай акт 2-ыг, үйлдэж гал түймрийн гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзсан материал 1 удаа үйлдэн, шийдвэрлэх ажиллагаа явуулсан байна.

Галын аюулгүй байдал нь хангагдсан аж ахуйн нэгж, байгууллагуудад ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт 5-ыг гаргаж 62500 төгрөг, 1 барилгын зураг хянаж 50000 төгрөг, нийт 112500 төгрөгийг аймгийн Татварын хэлтсийн дансанд төвлөрүүлэн ажиллалаа.

Гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажлын талаар: Сүүлийн жилүүдэд цаг агаарын гамшигт үзэгдлийн давтамж, болзошгүй үерийн аюулт үзэгдэл жилээс жилд нэмэгдэж байгаатай холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх газраас ирүүлсэн “Болзошгүй үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах удирдамж”-ийн дагуу төлөвлөгөө гарган Онцгой байдлын газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. “Болзошгүй үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх” арга хэмжээний удирдамжийн хүрээнд Баруун-Урт сумын нутаг дэвсгэрт байрлаж буй үерийн далан, хамгаалалтын систем, ус өнгөрүүлэх суваг шуудууны ашиглалтын байдалд үзлэг хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, цэвэрлэгээ, засвар үйлчилгээний арга хэмжээг зохион байгуулж

бэлэн байдлыг хангах урьдчилан сэргийлэх зорилгоор Баруун-Урт сумын Засаг даргад албан мэдэгдэл хүргүүлж тайлан мэдээг авч ажиллалаа.

Гамшгийн эрсдэлийн үнэлгээний талаар: Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйл, Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/125 дугаар тушаал “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх заавар”-ын дагуу аймгийн 13 сумыг хамруулан ой хээрийн түймрийн эрсдэлийн үнэлгээ хийх аргачлалын дагуу Онцгой байдлын газар, Аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төв, Сумдын Засаг даргын тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран хээрийн түймрийн эрсдэлийн үнэлгээ хийсэн. Үнэлгээр аймгийн хэмжээнд ногоон түвшинд буюу бага эрсдэлтэй гарсан.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа явуулсан талаар: Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, болзошгүй гамшиг, аюулт үзэгдлийг цаг алдалгүй шуурхай мэдээлэх, анхааруулах сэрэмжлүүлэх мэдээ мэдээллийг ард иргэдэд түргэн шуурхай хүргэх зорилгоор ОБЕГ, Ус цаг уур орчны шинжилгээний хүрээлэнгээс ирүүлсэн урьдчилан сэргийлэх цаг агаарын мэдээг орон нутгийн 2 телевизээр нийт 4 удаа, Онцгой байдлын газрын Sukhbaatar.uridchilansergiileh facebook хаягаар цахим хэлбэрээр иргэдэд цаг үеийн мэдээллийг 2 удаа хүргэн ажилласан байна.

Мөн орон нутгаас хэвлэгдэн гардаг Сүхбаатарын өнгө сонинд урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, тухайн үеийн мэдээ мэдээллийн талаар 1 удаа нийтлүүлж ажилласан.

Гал түймэр, гамшиг осолтой тэмцэх талаар: Гал түймэр унтраах, аврах анги нь томилгоот харуул ээлжинд 31 удаагийн 720 цагийн үүрэг гүйцэтгэх хугацаанд объектын гал түймрийн 2 удаагийн дуудлага ирснээс зөрчлийн дуудлага –1, гал түймэр унтраах, аврах ажлын 1 удаагийн объектын гал дээр зохион байгуулж ажилласан.

Сургал тарга хэмжээ: Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны 2/535 тоот үүргийн хэрэгжилтийн хүрээнд “Гал түймэр унтраах тактик, тархалтын сургуулийн төлөвлөгөө, шуурхай карт боловсруулах аргачлал”-аар Гал унтраах тактикийн сургуулийг Цайрт минерал ХХК, тархалтын сургуулийг батлагдсан төлөвлөгөөний дагуу Баруун-Урт суманд үйл ажиллагаа явуулдаг Төрийн банк, Хас банк, Голомт банк, Хаанбанк, Эрдэнэцагаан сумын Ардчилсан намын байр, Хэрлэн кафе, хүүхдийн 2 дугаар цэцэрлэг, Баялаг мини маркет зэрэг байгууллагуудад шинэ төрлийн коронавирисын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор тархалтын сургуулийг танхимын хэлбэрээр зохион байгуулсан. Сургалтад аж ахуйн нэгж байгууллагаас 58 хүн хамрагдсан. Онцгой байдлын газраас давхардсан тоогоор 18 албан хаагч оролцсон.

Албан хаагчдын гал унтраах ур чадвар, сэтгэл зүй, бие бялдрыг хөгжүүлэх зорилгоор өдөр тутмын дасгал сургуулийг 31 удаа 62 цаг давхардсан тоогоор 217 албан хаагчийг хамруулж, амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах, аврах олс, байлдааны тархалт, хөдөлмөр хамгааллын хувцас өмсөлтөөр хийж гүйцэтгүүлсэн.

Бэлтгэл, бэлэн байдал, гамшигтай тэмцэх үйл ажиллагаа: Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, тогтоомж, галын аюулгүй байдалтай холбоотой стандарт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах, хаягжуулах, байнгын хэвийн ажиллагааг хангуулах ажлын хүрээнд Сүхбаатар аймаг Баруун-Урт суманд ашиглагдаж байгаа галын далд усны цэг /гидрант/ нь 1986 онд ашиглалтад орсон нийт 11 гидрантын ажиллагааг шалгахад 7 гидрант хэвийн ажиллагаатай байнгын даралт 1-2.0 МПа, 4 гидрант нь ажиллагаагүй болсон засварлах боломжгүй, цэвэр усны шугамын шинэчлэлийн ажил хийгдэж байгаатай холбогдуулж уг гидрантууд ашиглагдахгүй дахин төлөвлөлтөнд орж байгаа, Дөрвөлж, орон нутгийн өмчит үйлдвэрийн газраас 2020.06.23-ны өдрийн 5/183 албан бичгээр мэдэгдсэн.

Баруун-Урт сумын 7 дугаар баг “Ургах наран хороолол”-ын 115 тоотод N46676949 E113284375 байрлалтай хувийн дугаар №7 гидрант байнгийн даралт 2.0 МПа гал унтраах үндсэн албаны МАН загварын 3.5 тоннын автомашинд гидрантаас ачилт хийхэд нийт 8.46 минутанд дүүргэлтийн хугацааг тодорхойлсон. Одоо ашиглагдаж байгаа гидрантуудын хаяг байршил, координатыг тогтоож ангийн захирагчийн усан хангамжийн ажлын зураглалд оруулж, паспоржуулж ажилласан.

Сүхбаатар аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас Баруун-Урт суманд улсын төсвийн 1 тэрбум 662 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй цэвэр ус хангамжийн шугамын өргөтгөл шинэчлэлтийн ажлын галын далд усны цэг 31 төвлөсөн, шугам сүлжээний угсралтын ажлыг 8 сарын 30-нд дуусгах талаар мэдэгдсэн. Уг

ажлыг гүйцэтгэгч “МОН-КУЗБАСС” ХХК-аас шинээр ашиглалтанд орох нийт 31 галын далд усны цэг байршлыг тодорхойлсон зураглалыг гаргуулж авсан.

Баяр амралтын өдрүүдэд байлдааны үүрэг гүйцэтгэж буй тусгай зориулалтын автомашин, багаж зэвсэглэмж, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг 2 удаа шалган техникийн засвар үйлчилгээг хийн бэлэн байдлыг хангуулан, үндсэн болон туслах албаны зориулалтын 4 автомашины шатахууныг 80 хувьд хүргэж, шуурхай албаны 3 автомашиныг тус бүр 20 литр бензинээр цэнэглэж бэлтгэл бэлэн байдлыг хангаж ажилласан.

Гамшиг ослын дуудлагаар ажилласан талаар: Эрдэнэцагаан сумын Цагаан овоо 2 дугаар баг Бавхайт, Чоно гол гэдэг газарт 2020.07.03-ны өдөр усны ослын 2 дуудлага ирсэн тус дуудлагын дагуу аймгийн Гал түймэр унтраах, аврах 47 дугаар ангийн захирагч, ахлах дэслэгч М.Дамбаар ахлуулсан 6 алба хаагч, 1 автомашинтай эрэн хайх, аврах ажлыг зохион байгуулж буцалтгүй нэрвэгдэгчдийг гаргаж сумын цагдаагийн тасагт хүлээлгэн өгсөн. Мөн тус сумын Хөндлөн хайлааст багийн “Ширээгийн гол” гэдэг газар тогтоол усанд хүүхэд осолдсон дуудлагаар Гал түймэр унтраах, аврах 47 дугаар ангийн 4 алба хаагч ослын голомтод эрэн хайх аврах ажиллагааг зохион байгуулж 4 метрийн гүнээс гаргаж, сумын Цагдаагийн тасагт хүлээлгэн өгсөн.

Зургаа. Сумдад зохион байгуулагдсан ажил:

Баруун-урт:

Цаг үеийн ажлууд: Баруун-Урт сумын 7-р багийн нутаг дэвсгэрт дараах ажлууд хийгдэж байна.

- Нийтийн эзэмшлийн 48, 60 айлын орон сууцны дээвэр засварын ажлын тендерт Хайлааст гарам ХХК шалгарч ажлыг эхлүүлсэн, ажлын явц 70 хувьтай
- Ургах наран хороололд тоглоомын талбай шинээр барих ажлын тендерт Эм Эл Ти Кэй ХХК шалгарч ажлыг эхлүүлсэн, гүйцэтгэл 80 хувьтай
- Дөрвөлжийн 16 айлын орон сууцны дээвэр засварын ажлыг иргэдийн оролцоотой орон нутаг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 5-р багийн иргэн Н.Чулуунбаатар хийж гүйцэтгэсэн.
- Боловсрол хорооллын дунд шинээр тоглоомын талбай барих тохижилтын ажлыг хийж гүйцэтгэх ажлын тендерт Шинэ соёл ХХК шалгарч, ажлыг эхлүүлээд байна.

Сумын Засаг даргын 2020 оны А/150 дугаар захирамжаар 110 албан байгууллага, аж ахуй нэгж байгууллагад өөрийн эзэмшил газраас 50м хүртэлх зам талбайн шарилж, хогийн ургамлыг 8-р сарын 15-ны дотор устгах цэвэрлэх арга хэмжээ авч ажиллах албан мэдэгдлийг хүргүүлээд байна.

Иргэдийн эрүүл мэндийг хамгаала, ургамлын харшлаас урьдчилан сэргийлэх зорилгоор нийтийн эзэмшлийн зам талбай дахь шарилж ургамлыг устгах тендерийг зарласан ба “Билэгт тус хүү” Нөхөрлөл шалгарч шарилж устгах ажлыг эхлүүлээд байна.

Баруун-Урт сумын 8-р багийн малчдын нутаглаж буй нутаг, зам дагуух эзэнгүй хог хаягдлыг Цайрт минерал ХХК болон Талын гал ХХК-тай хамтарч цэвэрлэх ажлыг хийж нийт 210 м3 хогийг булаж, зөөвөрлөж устгах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Баяндэлгэр:

Нийгмийн халамж: Аймгийн ахмадын амралтанд 20 ахмадыг амруулсан. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд “Алсын-Оч” ХХК-ны эмч нар ирж ойрын харааны шил тохиоруулахад 85 ахмадууд хамрагдсан байна.

Соёл: Баяр наадмын үйл ажиллагаанд зориулан Соёлын төвөөс Монгол зан заншил өв уламжлалаа хадгалж хамгаалах, үр хойчдоо өвлүүлэн үлдээх зорилгоор морьтон залуусын дунд “Уурга шүүрэх “тэмцээн, “Монгол ардын дууг хэн сайн дуулах вэ?” ардын дууны тэмцээн, монгол морь, дээл хувцас эдлэл хэрэглэлээрээ гангарсан “Сайхан хос” шалгаруулах тэмцээнүүдийг амжилттай зохион байгууллаа.

Хорио цээрийн дэглэммөрдөгдөж байгаатай холбоотойгоор номын сан нь уншигчдад гэрээр болон цахимаар 160 ном олгож ажиллаа. Уншигчдад зориулан байгууллагын цахим хаягт өгүүллэг тууж, романуудыг цувралаар байршуулж байна.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: Бод, бог малын туулгалтын ач холбогдлыг малчдад сурталчилсаны үр дүнд малчид 15000 бог малд туулгалт хийлгэсэн байна.

Байгаль орчны чиглэлээр: Баяр наадмын үеэр “Хоггүй наадаа” уриалгыг гаргаж, хяналт тавьж ажиллав. Наадмын үйл ажиллагаанаас үүссэн 2 тонн хог хаягдлыг хогийн цэгт зөөвөрлөж хаялаа..

БОАЖЯ-ны санхүүжилтээр Хөдөө аж ахуйн их сургуулийн Агроэкологийн сургуулиас Ширээт багийн нутаг дэвсгэрт байрлах “Өлзийт булаг”-ийн эхийг хашиж хамгаалав.

Дарьганга:

Төрийн удирдлагын чиглэлээр: Сумын төсвийн байгууллагуудын 2020 оны хагас, бүтэн жилийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ-үнэлгээ хийх ажлын хэсгийг сумын Засаг даргын 2020 оны А/51 дүгээр захирамжаар 5 хүний бүрэлдэхүүнтэй томилон, удирдамж чиглэлийг батлуулан ажиллаж байна. Уг ажлын хүрээнд төсвийн байгууллагуудын удирдлагуудад 06.25 ны дотор хагас жилийн ажлын тайлан мэдээг 7 төрлөөр ирүүлэхийг мэдэгдсэн. Мэдэгдлийг хүлээн авсан 5 байгууллага тайлангуудаа ирүүлсэн. Уг тайланд хяналт шинжилгээ-үнэлгээ хийж, зөвлөмжийг хүргүүлээд байна.

Хагас жилийн хяналт шинжилгээ-үнэлгээний үр дүнгээр хамгийн нэн тэргүүн ээлжинд анхаарах асуудлаар Авлигатай тэмцэх газрын 2020.01.24 ний өдрийн 01/1004 тоот албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын явцад хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний талаарх зөвлөмжийг сумын ИТХ-ын ажлын алба болон сумын Засаг даргад албан бичгээр танилцууллаа.

2020 оны үйл ажиллагааны хагас жилийн тайланг 5 чиглэлээр нэгтгэж заасан хугацаанд ХШҮДАХ-т хүргүүллээ.

Хууль, эрх зүйн сургалт сурталчилгааны чиглэлээр: Ардын хувьсгалын 99 жилийн ойн баяр наадмын хүрээнд хурдан морь унаач хүүхдийн аюулгүй байдал, ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сумын ЭМТ-ийн ажилтан, сумын ЗДТГ-ын нийгмийн бодлогын мэргэжилтэн нар сурталчилгааг уяачид болон унаач хүүхдүүдэд хийж, 300 ширхэг гарын авлагыг гардуулж өгсөн.

2. Татварын улсын байцаагч, Байгаль орчны хяналтын улсын байцаагч нар хамтран баяр наадмын үеэр наадамчдад үйлчилгээ үзүүлж буй худалдаа үйлчилгээний 10 цэг салбарын үйлчлэгч нарт ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр гарын авлагыг цэг салбарт нь байршуулан, мэдээлэл өгч, худалдаа үйлчилгээ явуулах зөвшөөрлийг олгож, 400000 төгрөгийн хураамжийг төсөвт төвлөрүүллээ.

Сумын Засаг даргын 2020.07.06 ны А/58 дугаар захирамжаар наадмын 2 өдөрт мотоциклийн хөдөлгөөнийг бүрмөсөн хориглосон нь баяр наадам дэг журамтай зохион байгуулагдахад ихээхэн нөлөөлж үр дүнгээ өгсөн. Мөн баяр наадмын үеэр архи, согтууруулах ундаа худалдан борлуулах цагийн хуваарьт хязгаарлалт хийгдсэн.

Байгаль орчны чиглэлээр: Сумын БЦГХЗахиргаанаас Шилийн богдод тарвага болон хориотой ан агнуур хийхээс сэргийлж эргүүл пост ажиллуулж байгаагийн зэрэгцээ тухайн бүсийн ургамалжилтын судалгааг хийж байна. Хориотой ан агнуурын 1 зөрчлийг илрүүлж, хууль хяналтын байгууллагад хүлээлгэн өгсөн.

3 дугаар багийн нутаг Эрдэнэ-Уулын бургасыг хашиж хамгаалах ажлыг иргэдийн оролцоонд тулгуурлан нийт 18 гаруй малчдыг хамруулж, төсөл хөтөлбөрийн хүрээнд 1,5 сая төгрөгийн санхүүжилтээр багийн Засаг дарга, байгаль хамгаалагчид зохион байгуулж байна.

Хур бороо их хэмжээгээр орж нэгдсэн хогийн цэгийн хашлага далан сэтэрч эвдэрсэн тул сумын 10 иргэнийг хамруулан хогийн нэгдсэн цэгийг цэгцэлж байна.

Эрүүл мэнд: Засгийн газрын 224 дүгээр тушаалын дагуу эрүүл мэндийн чиглэлээрх сургалт сурталчилгааг хийж байна. Үүнд: 7 дугаар сард “Дэлхийн хүн амын өдөр” / дасгал хөдөлгөөн, эрүүл насжилт, 108 мөргөлийн ач тус/ сэдвээр 46 хүнд, “Тарваган тахлаас сэргийлье” сэдвээр 156 хүнд, “Коронавируст халдвараас сэргийлье” сэдвээр 57 хүнд тус тус сургалт сурталчилгаа хийв.

Баяр наадмын үеэр давхардсан тоогоор 436 уралдаанч хүүхдийн халууныг үзэж баталгаажуулан уралдааны замд гаргасан.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: Баяр наадмын үеэр наадмын талбайн 2 га талбайд Superkill бодисоор ариутгал халдваргүйжүүлэлтийг хийсэн.

Ноосны баримт баталгаажуулалтад 200 гаруй малчин өрх хамрагдахаас 65 өрх хамрагдаад байна.

Сумын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг борлуулах “Дарьгангад үйлдвэрлэл” борлуулалтын цэгийн ажил хэвийн явагдаж байгаа бөгөөд сур, суран эдлэлүүд, хөмүүл, таанын сорс зэрэг бүтээгдэхүүн борлуулалт сайтай байна.

Мөнххаан:

Төрийн удирдлага зохион байгуулалтын чиглэлээр: Сумын Засаг даргын 2018/08/06-ны өдрийн А/70 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэг МХГ-ын 2020/06/18 ны өдрийн 270 албан тоотын дагуу 27 дэлгүүр худалдаа үйлчилгээний газруудад хяналт шалгалт хийж тамхины зөвшөөрлийн хугацаа дууссан 3 дэлгүүрийн тусгай зөвшөөрлийг шинээр олгож 750,0 мян төгрөгийг 100120400941 дансанд төвлөрүүлсэн. Мөн шалгалтаар ОХУ-аас импортолсон 2020 оны 02 сарын 10,18 ны өдрүүдэд үйлдвэрлэсэн 308 13 4Р цувралын дугаартай Сайра нэрийн нөөшөлсөн загас 5 дэлгүүрээс 24 ширхэг гарсныг хураан авч устгал хийж тайлан мэдээг зурагжуулан аймгийн МХГ-т хүргүүлсэн.

Мал эмнэлгийн болон ХХАА-н чиглэлээр: МЭТасаг 242 гэрчилгээнд хянан баталгаажуулалт хийсэн. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд 27908 үхэр хамруулж, 55816 м/т вакцин зарцуулсан. Хагас жилийн мал тооллогын ажилд 10 төрийн албан хаагч ажилласан байна.

Байгаль орчин газар зохион байгуулалтын чиглэлээр : 280,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хүүхэд залуучуудын цэцэрлэгт хүрээлэнг “Хунт өгөөж” ХХК хийж гүйцэтгэн ЗДТГ-т хүлээлгэн өгсөн.

Сумын төвд 11 цамхагт гэрэлтүүлэг байрлуулах ажлын тендерт “Алсын солонго” ХХК шалгарч, өөрсдийн 100%-ийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэн хүлээлгэн өгөөд байна.

Сумын засаг даргын 2020 оны А/31 дүгээр захирамжаар 2 нэгж талбарт үйлчилгээтэй орон сууцны зориулалтаар , мөн 03 дугаар сарын 26-ны өдрийн А/37 дугаар захирамжаар уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалтаар 5 нэгж талбарт тус тус газрын дуудлага худалдааг амжилттай зохион байгуулж ажиллалаа. Нийт 7 нэгж талбарын дуудлага худалдааны үнэ болох 20.318.880 төгрөгийг төрийн сангийн 100120000943 болон 100120400943 тоот дансуудад төвлөрүүлээд байна.

11 монгол тарвагыг авчирч Мөнххаан ууланд нутагшуулсан.

Сумын төвийн худалдааны гудамж дагуух 400м замын ажлын тендерийг Ханан салхит ХХК авч замын ажлыг эхлүүлсэн ба ажлын гүйцэтгэл 80%-тай байна.

Хөдөлмөр эрхлэлт халамж, нийгмийн хамгааллын чиглэлээр: Хагас жилийн байдлаар халамжийн нийтийг хамарсан ажлын төслийн хүрээнд 70 иргэнийг түр ажлын байраар хангаж оготно устгал, хог цэвэрлэгээний ажилд ажиллуулсан. Бүлгийн ногоо тариалалт 6 иргэн ажиллаж байна. Ахмад настны амралт сувилалд 12 ахмад настан амраад байна. Насны хишиг 188 ахмад настанд 15400,0 мян төгрөг олгоод байна. Хүнс тэжээлийн дэмжлэг 88 өрхийн 399 иргэнд 28632,0 мян төгрөг олгосон.

Наран:

Хөдөлмөр эрхлэлт: Ажил зуучлалаар 11 иргэн шинэ ажлын байр 1 LIMS праграммд мэдээллэсэн. 12 сараас дээш бүртгэлтэй 1 иргэнийг Наран Түмэн эсгий ХХК-д зуучлан шинээр ажлын байр бий болгон ААНБ-тай гэрээ хийлээ.

Онгон:

Тамгын газар, төрийн удирдлагын ажлын чиглэлээр: "ongon.su.gov.mn" сумын вэб сайтыг нээлгэж үйл ажиллагаа явуулахад бэлэн болоод байна.

Төсөв санхүү: ОНХСангийн хөрөнгөөр 36,4 сая төгрөгийг спорт заалны засварт-20,0 сая, мал угаалгын ванн-7,2 сая, халуун усны зураг төсөв 9,2 сая төгрөгийг зарцуулаад байна.

СХСангийн эргэн төлөлт 82 хувьтай байна. СХСангийн дансанд 121,0 сая төгрөг байгаагаас 19 төсөлд нийт 111,5 сая төгрөгийн зээлийг иргэдэд олгоод байна. Эргэн төлөлтөөр 135,1 сая төвлөрсөн. 2020 онд нийт 15 төсөл иргэдээс ирсэн бөгөөд төсөл сонгон шалгаруулах ажлын хэсэг хуралдаж 5 иргэний 64 сая төгрөгийг олголоо.

Хөрөнгө оруулалт: Иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг шуурхай үзүүлэх хүрээнд сум дундын эмнэлэгт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Зөөврийн рентген /дагалдах хэрэгсэлийн хамт/-80сая, Унтуулгын аппарат-39,6 сая төгрөгийн тоног төхөөрөмж, Хүчил төрөгч аппарат 2, утлагын аппарат 2, халуун хэмжигч 3, памп 1-ийг тус тус шинээр авлаа.

Иргэд, хүүхэд залуусын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчныг бүрдүүлэх ажлын хүрээнд амралт, спорт талбайг байгуулан ашиглалтад хүлээн авлаа.

Хөдөө аж ахуй, байгаль орчин: Хавиргын булгийн эхийг хамгаалах ард иргэдэд байгаль орчноо хамгаалах дадал олгох зорилгоор ухуулах самбар байрлууллаа.

2020 онд 2 гад- төмс, 0,3 га-д хүнсний ногоо тариалсан. Услалтын системтэй талбайн 7 хувийг ашиглаж байна.

- ✓ Хөдөөгийн гурван багт 3 ширхэг мал угаалгын ванн барьж байна. 7 сард бүрэн ашиглалтад оруулна.
- ✓ 5 иргэнийг өдрийн 20000 төгрөгөөр цалинжуулан эзэнгүй хог хаягдалыг түүлгэх, цэцэрлэгт хүрээлэнгийн услагааны ажлуудыг тус тус хийлгэлээ.
- ✓ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1-р багийн нутаг гүйст, хадны хөв, баян зэрэг газруудад нийт 5000 га бэлчээрийг хамарч, энгийн механик болон биологийн аргаар үлийн цагаан огтонтой тэмцэх ажлыг хийлээ. Үүнд 20 малчин оролцож 6 хоног тус ажлыг хийж гүйцэтгэлээ.

Түвшинширээ:

Түвшинширээ суманд Их Монгол улс байгуулагдсаны 815 жилийн ой, ардын хувьсгалын 98 жилийн ойн баяр наадмаар сумын баяр наадмын комиссыг сумын Засаг даргын А/35 захирамжийн дагуу 5 салбар комисс томилон ажлуулсан байна. Сумын баяр наадмаар нийт 315 хурдан морь уралдаж, 98 хүүхэд унаж уралдлаа. Үүнд:

1. Их нас-90
2. Азарга-60
3. Соёолон-54
4. Хязаалан-37
5. Шүдлэн-35
6. Даага- 39 тус тус уралдсан байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөр, эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн зөвлөмжийн дагуу үндэсний их баяр наадмын морин уралдааны үеэр уралдаанч хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавигдах стандарт шаардлагыг хангуулж, уралдаанч хүүхдийн эрүүл мэнд аюулгүй байдалд хяналт тавьж дараах ажлуудыг хийж ажиллалаа.

Хөдөө аж ахуй, байгаль орчин: 07 сарын 20-23-ны өдрүүдэд усны асуудал хариуцсан байгууллагатай хамтран усны тооллого зохион байгуулсан ба 214 худаг тоологдсон байна. 2019 онд шинээр гаргасан гүн өрмийн 9 худаг, 2018 онд гаргасан 1 гүн өрмийн худгийг бүртгэлд нэмж оруулсан байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт: Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 01-р сарын 14-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан "Ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд сумын ажилгүй иргэдийг бүлгийн зохион байгуулалттайгаар хөдөлмөр эрхлүүлэхээр Түвшинширээ сумын "Хамтын хүч" нэртэй 5 иргэний бүрэлдэхүүнтэй баг байгуулагдаж ХЭДС-аас 5,0 сая төгрөгийн өртөгтэй тоног төхөөрөмжийг багийн ахлагч Б. Намсрайд хүлээлгэж өгөн үйл ажиллагааг нь эхлүүлсэн .

Түмэнцогт:

Төрийн удирдлагын чиглэлээр: Засаг даргын Сум хөгжүүлэх сангийн зээл олгох тухай А/74 дүгээр захирамжаар жижиг дунд үйлдвэрлэл шинээр байгуулах буюу үйл ажиллагаагаа өргөтгөх шинээр ажлын байр бий болгоход зориулан 4 иргэнд 38 сая төгрөгийн зээлийг олгосон.

Хөдөө аж ахуй: Мал эмнэлгийн газартай хамтран Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сумын хэмжээнд эцэг мал болох бух-91, хуц-310 ухна-136 нийт-537 цусны дээж авч холбогдох газарт хүргүүлээд байна.

Байгаль орчин: Баяр наадмын үйл ажиллагаатай холбоотойгоор цагдаагийн хэсэгтэй хамтран "Цэвэрхэн наадацгаая" уриалгыг 280 гаруй автомашины салхины

шилэнд нааж цахим бүлгүүдэд байршуулж уриалж иргэдийн санал, санаачлыг авч хэрэгжүүлж ажилласан.

Эрүүл мэндийн төвийн аюултай хог хаягдал хаях зориулалтын цэгийг байгуулах ажлыг эхлүүлсэн.

Үер усны аюулаас урьдчлан сэргийлэх гарын авлага боловсруулан 120 өрхөд багийн Засаг даргаар дамжуулан хүргэж, зөвөөр зөвлөмж өгч ажилласан.

- Зохион байгуулалттай ажлын байрны төсөлд хамрагдсан иргэдийн үйл ажиллагааг хянаж заавар чиглэл өгч ажилласан. Мөн төсөл хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг 2 хоног бүр хянаж ажлын цагийн бүртгэлийг хийж ажиллаж байна.

- Ажил хайгчаар бүртгүүлэх хүсэлт гаргасан 3 иргэний материалыг бүртгэсэн. Мөн ажил хайгчаар бүртгүүлээд 3 сар болж идэвхигүй болсон 16 иргэний мэдээллийг шинэчилж сэргээсэн.

- Сумын борлуулалтын цэгийн нэр төрлийг нэмэгдүүлж иргэдээс ирсэн бараа бүтээгдэхүүнийг борлуулж нийт 526,000 төгрөгний борлуулалт хийсэн.

- Гэрээт малчин хөтөлбөрт хамрагдсан 1 иргэний 4,5,6 сарын төлбөрийг төлүүлж баримтыг ХХҮГазарт хүргүүлсэн.

Нийгмийн халамж: ОНОТХҮ-ний төсөлд хамрагдсан 2 иргэний үйлдвэрлэсэн “Хогийн сав”-ыг ЗДТГазарт хүлээлгэн өгч “Үндэсний баяр наадам”-аар наадмын талбайд байрлуулсан.

Нийгмийн даатгал: Ажил олгогчоос орсон орлого 25 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого төгрөг 1.5 сая төгрөгийн орлого, Сайн дурын даатгалын орлого 1.3 сая төгрөгийг тус тус оруулсан. 363 тэтгэвэр авагчдад 160 сая төгрөгийн тэтгэврийг тавьж олгосон.

Нийгмийн даатгалын хуулийн өөрчлөлтийн талаарх мэдээллийг тэтгэвэр тогтоолгох 35 иргэнд зөвөлгөө өгч тэтгэврийн материалыг бүрдүүллээ. Нийт 23 ажил олгогч 5 сайн дурын даатгуулагч, 0-3 насны хүүхдээ асрах чөлөөтэй 18 эхийг нийгмийн даатгалын хуулийн чөлөөлөлтөнд 4 ажил олгогчийн 5 иргэнийг нийгмийн даатгалын дэмжлэгт хамруулж 1,0 төгрөгийг олгосон.

Соёлын төв: Ардын хувьсгалын 99 жилийн баяр наадмыг тохиолдуулан “Миний наадмын гоёл” үндэсний дээл хувцасаараа дэгжирхэн гоёх фото зургийн уралдааныг Түмэнцогт соёлын төв цахим хуудсаараа зарлалаа. Уг уралдааныг Түмэнцогт сумын Баялаг бүтээгчдийн холбоо хамтран зохион байгуулж баяр наадмын өдөр уралдаанд оролцсон 52 оролцогчдын дунд цахим сугалаа зохион байгуулж азтануудыг шалгаруулан Түмэнцогт сумын гар урлаачдын бүтээлээр шагналаа.

Сумын баяр наадмыг тохиолдуулан нүүдлийн соёлын өвийг өвлөн уламжлагч малчин ардыг алдаршуулах, уламжлалт ёс заншлаа сурталчлах, сумын баяр наадмын өнгийг нэмж монгол морины гайхамшгийг магтан дуулах, авьяастаныг тодруулах, монгол үндэсний соёл, дээл хувцсаараа бахархах зорилгоор “Морины дууны” уралдааныг зохион явууллаа.

Хорио цээрийн дэглэмийн үед иргэдэд өөрийн байгууллагын цахим хаягаар бүжгийн дасгал, цуврал хичээлүүд, хөдөлгөөн-Эрүүл мэндийн ач холбогдол, хөдөлгөөний дутагдалын талаарх зөвлөмжийг цувралаар хүргэж байна.

Энэ өдрүүдэд сумын орон нутгийн музей үйлчилгээгээр насанд хүрэгчид 16, хүүхэд 5 үзэж сонирхон танилцсан байна.

Соёлын биет буюу иргэдийн гар дээрх дурсгалын бүртгэлийг 3-р багийн 3 өрхийн 7 ширхэг өвөөр нэмэгдүүлэн бүртгэлжүүллээ.

Номын сангийн гэрээр ном олгох үйлчилгээгээр нийт 20 уншигчид 31 ш ном олгогдож үүнээс насанд хүрэгч 13, хүүхэд 7 хамрагдаад байна.

Үндэсний их баяр наадмын өдрүүдээр Түмэнцогт сумын иргэдийн төлөөлөл оролцуулан “Наадмын хууч” видео ярилцлага хийж Түмэнцогт Соёлын төв нүүр хуудсаар дамжуулан иргэдэд хүргэлээ.

Эрүүл мэндийн төв: Энэ сард эрүүл мэндийн төвийн амбулатороор 310 иргэн, алсын дуудлага 6, ойрын дуудлагаар 94 үйлчлэгч үйлчлүүлсэн байна.

Умайн хүзүүний хорт хавдрын эсийн шинжилгээнд эмэгтэй 20, Хөхний үзлэгт үйлчлүүлэгч 40 хамрагдаад байна.

ЭМТ-ийн амбулаторийн телевизээр Коронавирусын талаар 6 зөвлөмж, Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх 3 төрлийн сэрэмжлүүлэг бичлэгийг гаргаж байна.

Уулбаян:

Хөдөө аж ахуй: Сумын хэмжээн дэх нүхэн жорлонгийн судалгааг гарган нийт 237 нүхэн жорлонгоос 185 буюу 78%-д ариутгал халдваргүйжүүлэлтийг гээд байна.

Сумын хэмжээнд мал угаалгын 4 ваннаас 1 ванныг нь сэргээж засварлаад байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт: Ажил хайгч иргэнээр бүртгэгдсэн 83 гаруй иргэнээс 20 иргэний мэдээллийг шинэчлэхэд эмэгтэй-12, шинээр 10 иргэнийг ажил хайгчаар бүртгэхэд эмэгтэй-10 бүртгэгдлээ. Шинэ ажлын байранд-12 эмэгтэй-6, түр ажлын байранд-13 эмэгтэй-8 иргэн зуучлагдсан. Нийтийг хамарсан ажил, Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний төсөл, Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт-2, өмнөх онд авсан төслийн эргэн төлөлтийг хуваарийн дагуу төвлөрүүлж байна.

Ажилласан жил нөхөн төлүүлэхээр 22 хүний материалыг хүлээн авч НДХэлтэсээр шалгуулан 29532,0 мян төгрөгийг шимтгэлийг төвлөрүүлсэн.

Боловсрол: Дүйцсэн хөтөлбөрөөр 1 суралцагч, нийт 27 хүүхэд суурь боловсрол эзэмшиж гэрчилгээгээ гардан авсан.

Сумын хүүхэд хамгааллын хамтарсан багаас насанд хүрэгчдийн дунд хүүхэд хамгааллын чиглэлээр “Шилдэг шторк” шалгаруулах уралдаан зарлаж нийт 20 багш оролцов.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй 75 хүүхдийн дотуур байрын барилгын гүйцэтгэл 80 хувьтай. Мөн улсын төсвийн 150 сая төгрөгийн хөрөнгөөр дээврийн засвар хийгдэж байна.

Хүүхдийн цэцэрлэг: “Цэгээр наадъя” хөтөлбөрийн шалгаруулалтанд 4 хүүхэд бүтээлч хүүхэд, 3 гэр бүл бүтээлч гэр бүл, 1 багш онцлох багшаар шалгарлаа.

Соёл: Нийтийн номын сан групп хаягаар “Цахим уншлагад нэгдэцгээе” аян зохион байгуулж зохиол бүтээл байршуулж иргэдэд цахим үйлчилгээ үзүүлээ. Мөн Уулбаян Соёлын төв цахим хаягт “Нийтийн бүжиг” бусад мэдээлэл сурталчилгааг байршуулж байна.

Эрүүл мэнд: Урьдчилан сэргийлэх үзлэг-215, идэвхтэй хяналт-57, дуудлагаар гэрийн үзлэг-62, гэрийн идэвхтэй үзлэг-72, алсын дуудлага-48, жинлэсэн хүүхдийн тоо-21, артерийн гипертензи-117, хөх-145, эсийн шинжилгээнд-45 хамрагдаж нийт 1015 үзлэг хийж, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

Хууль, эрх зүйн чиглэлээр: Хүүхдийн тоогоор ажилласан жил нэмж байгаатай холбогдуулан 64 хүнд нийгмийн даатгалын хуулийн өөрчлөлтийн талаар мэдээлэл хийлээ.

Халзан:

Энэ сард аймгаас авах санхүүгийн дэмжлэгээр 37300,0 мянган төгрөг авч, сумын татварын орлогоор 972,4 мянган төгрөг орж нийт орлого 38272,4 мянган төгрөг орсон байна. Төсөвт байгууллагуудад 41234,6 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон байна. Үүнээс:

Ø ЗДТГ-28762,1

Ø ИТХ-6211,2

Ø Соёлын төв-6261,3

Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байгууллагуудын хувьд:

Ø ЕБС-8352,6

Ø СӨБ-3957,3

Ø ЭМТ-26758,7 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Энэ сард сум байгуулагдсаны 95 жилийн ойн баяр наадам болж өнгөрлөө. Наадмаар санхүүгийн алба аж ахуйн комисст орж ажилласан. Нийт орлого 12212,8 мянган төгрөг орж, зарцуулалт 11789,0 мянган төгрөг гарч, үлдэгдэл 423,8 мянган төгрөг байна.

Эрдэнэцагаан:

Ардын хувьсгалын баяр наадмыг эрүүл ахуйг хангасан, иргэдийн амгалан тайван байдлыг зохион байгуулах зорилгоор сумын Засаг даргын “Нийтийн дэг журмыг сахиулах” 2020 оны 119, “ Наадмын талбайд худалдаа үйлчилгээ явуулахыг хязгаарлах” 2020 оны 121 дүгээр захирамж гаргаж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа. Энэ үеэр худалдаа,

хоол үйлдвэрлэл үйлчилгээний 47 цэг, газруудад хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор зөвлөмж бэлтгэн хүргэж биелэлтийг хангуулж зөрчилгүй ажиллалаа.

Туслах малчдыг дэмжих бүлгийг Тамгын газрын даргаар ахлуулан томилж, 10 туслах малчны судалгааг холбогдох мэргэжилтэнээр гаргуулан гадаадын хөрөнгө оруулалттай төслийн газарт хүрүүллээ.

Сумын Төрийн албан хаагчдын ёс зүйн хагас жилийн тайланг сахилгын шийтгэл хүлээсэн 9 албан хаагчдын судалгааны хамт Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлсэн.

Төрийн үйлчилгээний ТҮЦ машинаас урьд нь 24 нэр төрлийн үйлчилгээ авдаг байсан бол WWW.E-MONGOLIA.MN сайтаас төрийн үйлчилгээний 11 байгууллагын 54 лавлагаа тодорхойлтыг гарган үйлчилж байна. Одоогийн байдлаар иргэний үнэмлэхний лавлагаа 17, оршин сууга хаягийн лавлагаа-2 нийгмийн даатгал шимтгэл төлөлтийн лавлагаа-5, регистрийн лавлагаа-2 гэрлэсний бүртгэлийн лавлагаа-1, бүрэн дунд боловсролын тодорхойлт-1 жолоочийн лавлагаа-1 үл хөдлөх хөрөнгийн лавлагаа-2 галт зэвсэг эзэмших лавлагаа-1, иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан лавлагаа-1 нийт 32 төрлийн лавлагаа, тодорхойлолт гаргаад байна.

Сумын Засаг даргын А/118 дугаар захирамжаар золбин нохой устгах ажлыг 2, 5, 8-р багуудын нутаг дэвсгэрт зохион байгуулж 122 золбин нохойг устгасан. Уг ажилд 1.5 сая төгрөг зарцуулагдав.

6 дугаар сарын 23-24-нд Ханын гол, Жавхлант, Бадрахын гол, Ширээ, зэрэг газруудад болсон байгалийн гамшигт үзэгдлийн улмаас учирсан хохирлын байдалтай газар дээр нь очиж танилцахад 18 өрхийн гэр орон, эд материал, машин техник эвдэрч, хонь ямааны нүд сохорч, хөл хугарч, арьс нь шалбарч үхсэн байна. Үүнээс 6 өрхийн гэр бүрэн эвдэрсэн байна. Хохирлыг үнэлгээний комиссоор тооцуулж холбогдох материалыг аймгийн Онцгой комисст, Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт хүргүүлэн ажиллалаа.